



WHITE PAPER

Блокчейн болон Финтекийн төгс хослол

Улаанбаатар. 2023



Мэдэгдэл

Та бүхэнд Монгол Улсын эрх зүйн орчны шаардлага, зохицуулалттай уялдуулан бид энэхүү танилцуулгыг шинэчлэн хүргэж байна.

Энэхүү танилцуулга нь Storepay үйлчилгээний цаашдын бизнесийн замнал, үүнтэй холбоотой Storepay үйлчилгээг олон улсад нэвтрүүлэхэд SPC токен болон SPC токений гүйцэтгэх үүрэг, эдгээрийн хэрэглээний талаар мэдээллийг хүргэх зорилготой юм.

Энэхүү танилцуулга нь SPC токенийг худалдан авах урилга, уриа, гэрээ хийхэд нөлөөлөх зорилгыг агуулаагүй бөгөөд тус танилцуулгыг уншсанаар тус токенийг худалдан авах гэрээний харилцаа үүсэхгүй болно.

SPC токенийг худалдан авахаас өмнө худалдан авагч холбогдох эрсдэлийг судалж, мэдлэг мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах үүрэгтэй бөгөөд уг танилцуулгын гол зорилго нь сонирхол бүхий этгээдийг шаардлагатай мэдээллээр хангах юм.

Стор Пэй ХХК-ийн зүгээс Стор Пэй Койн (SPC) токений хоёрдогч зах зээлийн үнэ ханш, тогтвортой, эрсдэлгүй байдлыг хариуцахгүй бөгөөд SPC токений хоёрдогч зах зээлийн үнэ ханш нь чөлөөт зах зээлийн зарчмаар нээлттэй явагдах болохыг анхаарна уу.

"Стор Пэй" ХХК-тай холбогдон анхны танилцуулгатай танилцах боломжтой.



Агуулга

02 Мэдэгдэл

04 I. Хураангуй үзүүлэлт

07 Тоогоор

12 Шинэ шийдэл /олон улсад

15 Зах зээлд нэвтрэхийн өмнөх Монголын санхүүгийн орчин ба асуудал

17 Асуудлын шийдэл

20 Дараагийн алхам-Блокчейн шилжилт

24 II. SPC токен загвар

25 SPC ашиглалт ба SPC wallet

27 SPC буцаан олголт буюу Mining

29 Эрэлт

31 Нийлүүлэлт

39 SPC Экосистем

41 III. Roadmap буюу ойрын ба хэтийн төлөвлөгөө

42 Дотоодын зах зээлийн хөгжил

1. Үйлчилгээг шинэ хэрэглэгчдэд хүргэх

2. Мерчант байгууллагын тоо болон хамтран ажиллах салбарын төрлийг нэмэгдүүлэх

3. Бүртгэлийн процессын шинэчлэл

4. Идэвхтэй хэрэглэгчдийн үйлчилгээний эрхийг нэмэгдүүлэх

5. Шинэ үйлчилгээнүүдийг Storepay 3.0 хувилбарт нэвтрүүлэх

51 Гадаадын зах зээлийн хөгжил

1. Олон улсын корпораци болох эхлэл тавигдсан

2. Эхний алхам: Лаосын зах зээл

3. Зүүн Өмнөд Азийн зах зээлийн тэлэлт

58 IV. Бүтэц, баг хамт олон



Хураангуй Үзүүлэлт

Storepay Coin | Whitepaper

Хураангуй үзүүлэлт



Storepay нь Монголын хамгийн олон хэрэглэгч, харилцагчтай **Buy Now, Pay Later** буюу **"Одоо аваад, дараа төл"** финтекийн хуваан төлөх шийдлийн үйлчилгээ үзүүлэгч компани юм.

Storepay-ийн онцлох тоон үзүүлэлтүүд:

2019 онд Монгол улсад үүсгэн байгуулагдсан, Финтек буюу санхүүгийн технологийн шинэлэг үйлчилгээ нэвтрүүлсэн

2020 оны 6 сард STOREPAY HOLDING PTE толгой компани Сингапур улсад үүсгэн байгуулагдсан

450,000 бүртгэлтэй хэрэглэгчийн баазтай

250,000 идэвхтэй, тогтмол хэрэглэгчтэй

2,700+ боломжит салбар, дэлгүүр үйлчилгээний төвтэй

Нийт 140 тэрбум төгрөгийн худалдан авалтын дүнгээр зах зээлд амжилт үзүүлээд байна.





Хураангуй үзүүлэлт



Storepay нь өөрсдийн дэд бүтцэд тулгуурлан “SPC” (Storepay Coin) шинэ криптовалютыг Монголын зах зээлд анхлан танилцуулсан.

SPC нь Binance Smart Chain-д суурилсан BEP20 стандартын токен бөгөөд Монгол болон Азийн хэрэглэгчдэд блокчейнд суурилсан худалдан авалтын урамшууллын ухаалаг ба өгөөжтэй шийдлийг санал болгож байна.

Бид хэтэвч, үндсэн үйлчилгээнд ашиглах, mining буюу буцаан олголт зэрэг SPC-ийн цогц экосистемийг бий болгохоор хөгжүүлэлтийн замналаа төлөвлөж, Монголын зах зээлээс цар хүрээгээ Зүүн Өмнөд Азийн 676 сая хэрэглэгчтэй зах зээл рүү өөрсдийн үйлчилгээг тэлж, түүнийг дагаад SPC-г нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна.



Toogoop

Storepay Coin | Whitepaper



Storepay / Тоороо



2,700+

Боломжтой салбар дэлгүүр,
үйлчилгээний газрууд

430,000+

Нийт хийгдсэн
худалдан авалт

250,000+

Идэвхтэй хэрэглэгчид

450,000+

Бүртгэлтэй хэрэглэгчид

140 тэрбум ₮

Нийт худалдан авалтын дүн

11.2 тэрбум ₮

Хэрэглэгчдэд үүсгэсэн
хэмнэлт







Storepay / Тоороо



Storepay
Худалдан авалтын
дүн



Storepay
Бүртгэлтэй
хэрэглэгч



Storepay
Боломжтой салбар,
дэлгүүрүүд



Storepay / Тоорооп



Storepay LLC, Mongolia

Үүсгэн байгуулагдсан
2019.01.23



Storepay Holding, Singapore

Үүсгэн байгуулагдсан
2020.06.22



Storepay, Indonesia

Бүтэц, холболт, борлуулалтын
ажлууд хийгдэж байгаа
2022.09





Шинэ шийдэл

/ Олон улсад /

Storepay Coin | Whitepaper



Шинэ шийдэл



Санхүү, төлбөр тооцооны гол хэрэгслүүдийн нэг болох Кредит Карт буюу банкны зээлийн карт нь хэрэглэгчийн төлж буй хүү, шимтгэл, хураамжаас ашиг бүрдүүлдэг бизнес модель юм.

Энэ бүтээгдэхүүний дийлэнх хэрэглэгчид нь тодорхой хэмжээнд төлбөр төлөх хугацаагаа хэтрүүлж, хугацаа хэтрэлтийн хүү, шимтгэлийн төлбөрөө хийдэг. Жишээ нь, зөвхөн 2019 онд гэхэд АНУ-д 121 тэрбум ам.долларыг хэрэглэгчид Кредит Картын хүү, шимтгэлд төлсөн байна.

Энэ нь банкны хувьд ашигтай бүтээгдэхүүн боловч санхүүгийн дарамтад орох, хяналтгүй хэрэглээ зардлыг нэмэх, өндөр хүү шимтгэл төлөх, өрийн хуримтлал үүсгэх зэрэг олон сул талуудыг хэрэглэгчдэд бий болгодог. Зээлийн картын үйлчилгээтэй ижил төрлийн Монголд түгээмэл байдаг бичил зээлийн бүтээгдэхүүн ч мөн адил зарчмаар ажилладаг.

Тэгвэл Buy Now, Pay Later буюу одоо аваад дараа төлөх (цаашид BNPL гэж товчилсон болно) бизнес модель нь дээрх асуудлуудыг шийдэх зорилготойгоор анх 2014 онд Австрали улсад үүсэн зах зээлд нэвтэрч, банк санхүү, төлбөр тооцооны салбарт цоо шинэ хувьслыг эхлүүлсэн байдаг.





Шинэ шийдэл

Тухайн үйлчилгээ нь хэрэглэгчийн хувьд дараах давуу талтай:

Хүү, шимтгэл,
нэмэлт төлбөргүй

Төлбөрийн таатай
нөхцөлтэй

Орлого, зарлагаа
төлөвлөх боломжтой

Урт хугацааны
санхүүгийн дарамтгүй

Энэхүү төлбөрийн шийдэл нь үүсэж хөгжсөн цагаасаа хойш асар хурдтайгаар дэлгэрч, банкны зээлийн карт зэрэг бичил зээлийн үйлчилгээг орлох боллоо. Өнөөдрийн байдлаар Австрали, АНУ, Европын улс орнуудад BNPL үйлчилгээ өргөнөөр нэвтэрснээр дэлхийн санхүү, техник технологийн хөгжлийг тодорхойлогч “Giant” компаниуд болох PayPal, Square, Amazon энэ бизнест хөрөнгө оруулж, Afterpay, Affirm, Paily зэрэг BNPL үйлчилгээ үзүүлэгч финтек компаниудтай хамтран ажиллаж эхэллээ.

BNPL бизнесүүд техник технологийн хөгжлийг өөртөө улам бүр шингээснээр илүү хялбар, таатай технологид суурилсан санхүүгийн үйлчилгээнүүдийг нэвтрүүлж буйн томоохон жишээ нь blockchain технологийг BNPL бизнест ашиглаж эхэлсэн нь юм.



Зах зээлд нэвтрэхийн өмнөх Монголын санхүүгийн орчин ба асуудал

Storepay Coin | Whitepaper



Монголын санхүүгийн орчин

Банк санхүүгийн байгууллагуудын голлох үйлчилгээ нь зээл, хадгаламж болон лизинг бөгөөд бага үнийн дүнтэй худалдан авалтад зориулсан лизингийн үйлчилгээ ховор, кредит картын үйлчилгээ түгээмэл бус.



Иргэд зээл, лизинг ашиглан худалдан авалт хийснээр сар бүр хүү, шимтгэлд нь өндөр төлбөр, эцэст нь худалдан авалтын үнийн дүнгээс дунджаар 20-50% илүү мөнгөн дүнг төлөх болдог. Энэ бүхний эцэст оролцогч гурван талын аль алинд ашиггүй нөхцөл үүсдэг:

- Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээг ашиглах хэрэглэгчийн тоо багасаж;
- Иргэд хэрэгцээтэй худалдан авалтаа хийж чадахгүй байдал үүсэж;
- Бизнесийн хувьд хэрэгцээтэй бараа, үйлчилгээний борлуулалт хязгаарлагдана.

Бараа эргэлт, борлуулалтаа нэмэгдүүлэхийн тулд худалдааны салбарынхан маркетингийн үйл ажиллагаанд их хэмжээний зардал гаргах, хямдрал урамшуулал зарлах зэргээр бизнесийн ашигт ажиллагаа багасах гэх мэт зах зээл дээр хоорондоо харилцан холбоотой тодорхой асуудлууд үүсэж байв.



Асуудлын шийдэл

Storepay Coin | Whitepaper



Асуудлын шийдэл

“Стор Пэй” ХХК нь 2019 оны нэгдүгээр сарын 23-ны өдөр иргэд болон бизнесүүдэд тулгараад байсан дээрх асуудлуудыг шийдэх зорилготой үүсгэн байгуулагдсан.

Бид технологийн хөгжил дэвшлийг санхүүгийн цоо шинэ BNPL (Одоо аваад, дараа төл) модельтой нэгтгэн арван сарын турш судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг хийж, 2019 оны арван нэгдүгээр сард Монгол улсын санхүүгийн зах зээлд анх удаа ямар ч хүү, шимтгэлгүй хуваан төлөх үйлчилгээг нэвтрүүлэв.



Ингэснээр, иргэд ямар нэгэн хүндрэл чирэгдэлгүйгээр 100,000 – 10,000,000 төгрөгийн хооронд Storepay-ийн гэрээт газруудаас ямар нэгэн нэмэлт төлбөргүй, зөвхөн тухайн худалдан авалтын төлбөрийг хуваан төлөх нөхцөлтэйгээр авах боломжтой болов. Энэ нь:

Хэрэглэгчийн хувьд

- Санхүүгийн таатай нөхцөлөөр худалдан авалт хийх
- Хүү, шимтгэлд өндөр төлбөр төлөхгүй байх
- Цалин, орлогод уялдуулан санхүүгээ төлөвлөх

Харилцагч байгууллагын хувьд

- Илүү олон худалдан авагчид бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэх
- Борлуулалтын шинэ бөгөөд хялбар сонголтыг үйлчлүүлэгчдэд санал болгох
- Худалдааны бодит эргэлт, өсөлтөө нэмэх
- Хамтарсан маркетинг хийж, брэндийн танигдалт борлуулалтыг нэмэх зэрэг давуу талуудыг өгсөөр байна



Асуудлын шийдэл

Бид Storepay үйлчилгээг иргэд болон бизнесүүдийн өдөр тутмын худалдан авалт, үйлчилгээнд өргөнөөр ашиглах санхүүгийн гол хэрэгслүүдийн нэг болгон хөгжүүлж байна.

Бидний дараагийн алхам бол Монголын зах зээлд амжилттай туршигдаж, нотлогдсон бизнесийн загвараа Зүүн Өмнөд Азийн 676 сая хэрэглэгчтэй зах зээлд нэвтрүүлэх бөгөөд энэхүү ажлаа бодитоор эхлүүлээд байна.




713,177+

Аппликейшний татан авалт

Дараагийн алхам

/ Блокчейн шилжилт /



SPC
StorePay Coin

Storepay Coin | Whitepaper



SPC
StorePay Coin

Bitcoin Smart Chain-д суурилсан BEP20 стандартын криптовалют

Блокчейн технологи нь бүх төрлийн бизнесийн салбарт, мөн иргэдийн хэрэглээнд олон төрлийн шинэчлэл дэвшлийг авчирч байна.

Ихэнх хэрэглэгчдийн хувьд криптовалют нь шинэлэг бөгөөд өндөр эрсдэлтэй арилжааны хэрэгсэл мэтээр ойлгогдож байгаа хэдий ч, урт хугацаандаа хөгжлийн замнал нь тогтворжиж, зах зээл хэрсүүжиж, технологи нь жигдрэхийн хэрээр криптовалютын суурь болох блокчейн технологи маш олон давуу талыг бий болгож байна.





Блокчейн технологи нь

Орон зайд
хязгаарлагддаггүй буюу
бодит утгаараа глобал

Хэрэглэхэд хялбар
ба маш хурдан

Мэдээлэл
солилцоо
ил тод


Өндөр зэрэглэлийн
буюу криптограф
хамгаалалттай

Тэгвэл криптовалютын хувьд иргэдийн дунд гардаг гол шүүмжлэлүүд нь хэрэглээгүй, зөвхөн “speculative” арилжааны хэрэгсэл буюу ханшийн өсөлт, уналт дээр мөрийцөн ашиг хүртэх, алдагдал хүлээх боломжийг дагуулсан хэрэгсэл гэсэн ойлголт түгээмэл бий.

Үүний гол шалтгаан нь ихэнх токенийг гаргаж байгаа бизнесүүд нь шинээр гарч байгаа стартапууд бөгөөд өөрсдийн санааг бодит болгох хөрөнгийг босгох зорилготой гарч байгаа нь эрсдэлийг дагуулдаг.



Тэгвэл бизнесийн талаас SPC эдгээр асуудлыг бодитоор шийдвэрлэсэн дараах давуу талуудтай:



SPC нь Storepay үндсэн үйлчилгээнд ашиглагдаж эхэлснээр урамшуулал буцаан олголтыг илүү боловсронгуй болгох өдөр тутамд ашиглагдах боломжтой зах зээлийн эргэлтэд шууд орох бололцоо бүхий шинэ төрлийн цахим хөрөнгө болсон.

Бизнесийн хувьд SPC нь Storepay-ийн Зүүн Өмнөд Азийн зах зээлд бүтээгдэхүүн үйлчилгээгээ нэвтрүүлэх төлөвлөгөөний суурь болж байгаа бөгөөд Монгол болон бусад Storepay үйлчилгээ нэвтэрсэн зах зээлүүдэд нэгдмэл байдлаар хил хязгаар орон зайг хамаарахгүйгээр ашиглагдах боломжтой санхүүгийн бодит хэрэглээтэй бүтээгдэхүүн болгон хөгжүүлээ.



SPC TOKEN

Storepay Coin | Whitepaper



SPC ашиглалт ба SPC wallet


Storepay Coin | Whitepaper



SPC ашиглалт ба SPC wallet

SPC нь Storepay үйлчилгээний 450,000 гаруй хэрэглэгчдийн, 2,700+ гаруй гэрээт байгууллагуудаас хийгдэж буй худалдан авалтад, мөн худалдан авалтын буцаан олголт, цоо шинэ үйлчилгээ болох SPC wallet үйлчилгээнүүдэд ашиглагдаж байна.

SPC Wallet-ын онцлох функцууд:



SPC буцаан олголт буюу Mining

Storepay Coin | Whitepaper



SPC буцаан олголт буюу Mining



Хэрэглэгчдийн хувьд Storepay үйлчилгээг ашиглан хийсэн худалдан авалтаа хугацаандаа төлж дуусах бүрдээ үнийн дүнгийн 0,5%-тай тэнцэх үнэлгээтэй SPC буцаан олголт авах боломжтой.

Энэхүү буцаан олголт нь Storepay хэрэглэгчдийг урамшуулах, хэрэглэгчдийн тоо, худалдан авалт SPC токений хэрэглээг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Storepay-ийн үйл ажиллагаа өргөжин тэлж, худалдан авалтаас үүссэн SPC буцаан олголт буюу майнинг хийгдсэнээр SPC токений хэрэглээ, эрэлт нэмэгдэн үнэ цэнийн өсөлт бий болох юм.





Эрэлт

Storepay Coin | Whitepaper



Эрэлт

SPC нь дотоод болон гадаадын криптовалютын биржүүдэд хөрөнгө оруулалтын хэрэгслээр ашиглагдахаас гадна Storepay үндсэн үйлчилгээнд ашиглах, худалдан авалтын буцаан олголт зэрэг хэлбэрээр зах зээлийн эрэлт, нийлүүлэлт нь хангагдаж явах бөгөөд ингэснээр SPC-ийн тогтмол “хэрэглээтэй” байдал нь хангагдаж, тогтмол гүйлгээнд байна.

SPC токений эрэлт Storepay хэрэглэгчдийн тоог даган шууд хамааралтай байдлаар нэмэгдэж байгаа бөгөөд SPC токений IEO (Initial Exchange Offering) хийгдсэнээс хойш хэрэглэгчид SPC токенийг Монголд үйл ажиллагаа явуулж буй крипто биржүүдээс худалдан авч Storepay үйлчилгээнд ашиглаж байна.

Storepay үйлчилгээ нь зах зээлд аль хэдийнээ нэвтэрсэн байнгын худалдан авалт, тогтмол идэвхтэй хэрэглэгчийн баазтай тул хэрэглээнд шууд нэвтэрсэн ба Storepay апп дээрх үндсэн үйлчилгээнд ашиглагдах эрэлт үүсгэх давуу талтай байна.

Цаашлаад Зүүн өмнөд Азийн 676 сая хэрэглэгчтэй зах зээлд Storepay үйлчилгээг нэвтрүүлж, SPC-г олон улсын төвлөрсөн бус (decentralized- DEX) болон төвлөрсөн (centralized – CEX) биржүүд дээр гаргаснаар SPC-ийн эрэлт, хэрэглээ нэмэгдэх боломжтой.

Нийлүүлэлт

Storepay Coin | Whitepaper




Нийлүүлэлт



SPC

SPC токений IEO-д нийт токений 15% буюу 90 тэрбум SPC токен Монгол улсын зах зээлд гарсан бөгөөд энэхүү нийлүүлэлт нь цаашдын Storepay үйлчилгээнд ашиглагдах токений эрэлтийг хангаж ажиллана.

Storepay худалдан авалтад хэрэглэгч төлбөрөө хугацаандаа төлж дуусах үед үнийн дүнгийн 0,5%-д SPC токен буцаан олголт олгогдох бөгөөд буцаан олголт, урамшуулалд олгогдох SPC токен нь урамшууллын пүүлээс олгогдож байна. Урамшууллын пүүлээс токен олгогдож байна гэдэг нь эргээд Storepay үйлчилгээний эрэлт хэрэгцээ зах зээлд нэмэгдэж, өргөжин тэлж байгаагийн илрэл бөгөөд шууд хамаарлын зарчмаар SPC токений эрэлтийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болох юм.





Нийлүүлэлт

SPC IEO

Койны нэр:	StorePay Coin
Тикер:	SPC
Blockchain:	Binance Smart Chain
Address:	BEP20
Нийт нийлүүлэлт:	600,000,000,000
IEO нийлүүлэлт:	90,000,000,000
IEO үнэлгээ:	0.20₮
IEO татан төвлөрүүлэлт:	18,000,000,000₮
IEO эхлэх хугацаа:	2021.10.27 11:00
IEO дуусах хугацаа:	2021.10.29 17:00
IEO явагдах бирж:	trade.mn
Нэг хүний лимит:	15,000,000₮

SPC койны хуваарилалт

Нийт нийлүүлэлт:	600,000,000,000 / 100%
IEO:	90,000,000,000 / 15%
Хоёрдогч зах зээлд:	60,000,000,000 / 10%
Storepay Holding Singapore:	180,000,000,000 / 30%
Хөрвөх чадвар:	60,000,000,000 / 10%
Олон улсын стратегийн түншлэл:	66,000,000,000 / 11%
Урамшуулал, идэвхжүүлэлтийн сан:	54,000,000,000 / 9%
Үүсгэн байгуулагчид, баг бүрэлдэхүүн, зөвлөх:	30,000,000,000 / 5% (Locked for 1 year)
Стратегийн нөөц:	60,000,000,000 / 10%

Storepay Coin

Дахин хэвлэгдэх боломжгүй, шатаах боломжтойгоор үүсгэгдсэн.



Нийлүүлэлт

SPC Шатаалт

SPC токен болон Storepay үндсэн үйлчилгээний хоорондын уялдаа холбоог нэмэгдүүлэх, экосистемийг тогтмол сайжруулах хэрэглэгчийн тоо, худалдан авалтын тоо болон дүн эрс нэмэгдсэнтэй холбоотой SPC токений зах зээлийн үнэ цэнийг хадгалах, нэмэгдүүлэх зорилгоор анх үүсгэсэн SPC токений 73.43%-тай тэнцүү хэмжээний буюу нийт 440 тэрбум гаруй SPC токенийг шатаагаад байна.

2021 оны 12-р сарын 31-нд

- 2021 оны 11-р сарын 25-аас хойш 12-р сарын 31 хүртэлх хугацаанд худалдан авалтын 1%-иар олгогдсон 200 сая орчим SPC-г зах зээлээс худалдан авсан.
- “Хоёрдогч зах зээлд нийлүүлэх эсвэл шатаах” нийт 60 тэрбум SPC сангаас бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлттэй уялдуулан 30 тэрбум ширхэг буюу нийт SPC токений 5%-ийг шатаасан.



Нийлүүлэлт

SPC Шатаалт

2022 оны 3-р сарын 17-нд

- Storepay 3.0 хувилбарын экосистемийг дэмжих, инфляц үнийн өсөлтийн эсрэг SPC үнэ цэнийг өрсөлдүүлэх, нэмэгдүүлэх, гадаад зах зээлд Storepay & SPC нэвтрүүлэлтэд эерэг эрүүл токеномикс бүрдүүлсэн байх зэрэг үндэслэлээр 220 тэрбум ширхэг SPC шатаасан.
- Хугацаандаа төлж дууссан худалдан авалтын үнийн дүнгийн 1%-д олгож байгаа урамшууллын SPC-тэй тэнцүү хэмжээний SPC-г зах зээлээс үндсэн үйлчилгээнд ашиглагдан орж ирж буй SPC-ээс 14 хоног тутам шатаалт хийх шийдвэрийн дагуу 205 сая SPC шатаасан.

2022 оны 3-р сарын 17-ны өдрийн шатаалтын хүснэгт	Өмнөх үлдэгдэл	Шатаалт	Шатаалтын дараа
Нийт үлдэгдэл:	570 тэрбум	220 тэрбум	350 тэрбум
IEO:	90 тэрбум	-	90 тэрбум
Хоёрдогч зах зээлд:	30 тэрбум	-	30 тэрбум
Storepay Holding Singapore:	180 тэрбум	100 тэрбум	80 тэрбум
Хөрвөх чадвар:	60 тэрбум	30 тэрбум	30 тэрбум
Олон улсын стратегийн түншлэл:	66 тэрбум	30 тэрбум	36 тэрбум
Урамшуулал, идэвхжүүлэлтийн сан:	54 тэрбум	30 тэрбум	24 тэрбум
Үүсгэн байгуулагчид, баг бүрэлдэхүүн, зөвлөх:	30 тэрбум	-	30 тэрбум
Стратегийн нөөц:	60 тэрбум	30 тэрбум	30 тэрбум



Нийлүүлэлт

SPC Шатаалт

2022 оны 6-р сарын 30-нд

- Storepay B2B буюу Storepay үндсэн үйлчилгээ болон SPC хоорондын уялдаа холбоог улам нэмэгдүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээ экосистемд шинээр нэвтэрч байгаатай холбоотойгоор нийт сангуудаас 185 тэрбум ширхэг SPC шатаасан.

2022 оны 3-р сарын 17-ны өдрийн шийдвэрийн дагуу Амжилттай төлж дууссан худалдан авалтын үнийн дүнгийн 1%-д олгож байгаа урамшууллын SPC-тэй тэнцүү хэмжээний SPC-г зах зээлээс үндсэн үйлчилгээнд ашиглагдан орж ирж буй SPC-ээс 14 хоног тутам шатаалт хийх шийдвэрийн дагуу 9-р сарын 15 хүртэлх хугацаанд 1,7 тэрбум ширхэг SPC токен шатаагаад байна.

2022 оны 6-р сарын 30-ны өдрийн шатаалтын хүснэгт	Өмнөх үлдэгдэл	Шатаалт	Шатаалтын дараа
Нийт үлдэгдэл:	350 тэрбум	185 тэрбум	165 тэрбум
IEO:	90 тэрбум	-	90 тэрбум
Хоёрдогч зах зээлд:	30 тэрбум	27 тэрбум	3 тэрбум
Storepay Holding Singapore:	80 тэрбум	75 тэрбум	5 тэрбум
Хөрвөх чадвар:	30 тэрбум	25 тэрбум	5 тэрбум
Олон улсын стратегийн түншлэл:	36 тэрбум	31 тэрбум	5 тэрбум
Урамшуулал, идэвхжүүлэлтийн сан:	24 тэрбум	-	24 тэрбум
Үүсгэн байгуулагчид, баг бүрэлдэхүүн, зөвлөх:	30 тэрбум	-	30 тэрбум
Стратегийн нөөц:	30 тэрбум	27 тэрбум	3 тэрбум



Нийлүүлэлт

SPC Шатаалт

Нийт хугацаанд анх үүсгэсэн SPC токений 73.43%-ийг шатааснаар шинэ хуваарилалт дараах байдалтай байна. Нийт SPC токений талаас дээш хувийг SPC токен эзэмшигчид эзэмшиж байгаа буюу хоёрдогч зах зээлд байршиж байна.

2023 оны 2 сарын 1-ний өдрөөс эхлэн Storepay үйлчилгээний худалдан авалтын урамшууллын SPC буцаан олголт 1% байсныг 0.5% болгож 15 хоног тутмын шатаалтыг 1% хэвээр шатааж эхэлсэн. Энэхүү шинэ шатаалтын зарчим нь зах зээл дээр байгаа SPC токеныг тогтмол хорогдуулах бөгөөд худалдан авалтын төлбөрт оролцуулан ашигласан SPC шатаалтын дүнд хүрэхгүй тохиолдлуудад зах зээлээс SPC токенийг худалдан авч шатаалтыг хийж байна.

SPC токений хуваарилалт	SPC токений шатаалтын дараах үлдэгдэл	Хувь
Нийт үлдэгдэл:	159,428,746,768	100%
IEO:	90,000,000,000	56.45%
Хоёрдогч зах зээлд:	3,000,000,000	1.88%
Storepay Holding Singapore:	5,000,000,000	3.14%
Хөрвөх чадвар:	5,000,000,000	3.14%
Олон улсын стратегийн түншлэл:	5,000,000,000	3.14%
Урамшуулал, идэвхжүүлэлтийн сан:	18,428,746,768	11.56%
Үүсгэн байгуулагчид, баг бүрэлдэхүүн, зөвлөх:	30,000,000,000 (Locked for 1 year)	18.82%
Стратегийн нөөц:	3,000,000,000	1.88%



Нийлүүлэлт

Хөрөнгийн зарцуулалт

Энэхүү IEO-ээс татан төвлөрүүлсэн нийт хөрөнгө нь Storepay үйлчилгээний Монгол дахь зах зээлийн өргөжин тэлэлтэд зарцуулагдах бөгөөд нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн 90% буюу 16.2 тэрбум төгрөг эргэлтийн хөрөнгө хэлбэрээр, 6% буюу 1.08 тэрбум төгрөг платформын шинэчлэлт хөгжүүлэлтэд, 4% буюу 0.7 тэрбум төгрөг маркетинг идэвхжүүлэлтэд төлөвлөгдсөн.



Нэмэгдэх хүчин чадал

Нэмэлт хөрөнгө оруулалтыг Монголын зах зээл дэх Storepay үйлчилгээнд эргэлтийн хөрөнгө хэлбэрээр оруулснаар одоогийн хүчин чадал болох сарын 3 тэрбум төгрөгийн худалдан авалт гүйцэлдүүлэх чадвар нь 40 тэрбум болж нэмэгдэх буюу сард 80,000 худалдан авалт хийгдэх боломжтой болох юм. Энэ нь Storepay үйлчилгээ Монголын зах зээлд 500,000 идэвхтэй хэрэглэгчид үйлчлэх хүчин чадалд хүргэхээр тооцоологдсон бөгөөд одоогоор бид 250,000 идэвхтэй хэрэглэгчид үйлчилгээгээ хүргэн ажиллаж байна.





SPC Экосистем

Storepay Coin | Whitepaper




SPC Экосистем

Storepay Coin нь Storepay үндсэн үйлчилгээ, түүний дэд бүтцийн экосистем дээр суурилахаараа хамгийн онцлог юм.

Ингэснээр одоогийн Storepay үйлчилгээнд нэгдсэн 2,700+ дэлгүүр үйлчилгээнүүд, 450,000+ гаруй хэрэглэгчдийн өдөр тутмын тогтмол худалдан авалт, Storepay үйлчилгээ ашиглалтын дэд бүтэц дээр суурилсан экосистем үүсэх юм.

Цаашдаа энэхүү экосистемийн цар хүрээ нь Storepay үндсэн үйлчилгээний хүртээмжтэй уялдаатайгаар өргөжин тэлнэ.

Бид онлайн дэлгүүр, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үйлчилгээнд Storepay ашиглах боломжийг нээж экосистемийн эрүүл тэлэлтийг үүсгэж байна.





Рoadmap буюу ойрын ба хэтийн төлөвлөгөө

Storepay Coin | Whitepaper



Дотоодын зах зээлийн хөгжил

Storepay Coin | Whitepaper



Дотоодын зах зээлийн хөгжил

1.

Үйлчилгээг шинэ хэрэглэгчдэд хүргэх

Storepay нь зах зээлд нэвтэрсэн өдрөөс хойш органикаар буюу хэрэглэгч, үйлчлүүлэгчид өөрийн сонирхлоор Storepay үйлчилгээнд бүртгүүлж, эрхээ нээлгэн ашигласаар өнөөдрийн байдлаар 450,000 гаруй хэрэглэгч, 2,700 гаруй хамтран ажиллагч мерчанттай болоод байна.

Монголын санхүүгийн зах зээлийн судалгаа, шинжилгээг хийхэд Storepay үйлчилгээ нь одоогийн байдлаар боломжит зах зээлийн 30%-д хүрсэн байгаа бөгөөд цаашид өргөжин тэлэх боломжтой томоохон зах зээл байгааг тодорхойлсон.



SPC токенийг нэвтрүүлснээр Storepay үйлчилгээ нь маркетингийн идэвхжүүлэлт, кампанит ажлыг эхлүүлж, хэрэглэгчдийн тоог боломжит дээд хэмжээнд хүргэн ажиллахаар төлөвлөгөөндөө тусгаад байна.

2021 оны арван нэгдүгээр сараас эхлэн бид хэрэглэгчдийн тоог ахиулах зорилгоор олон нийтэд чиглэсэн томоохон кампанит ажлуудыг явуулж байгаа ба зөвхөн Улаанбаатар хот гэлтгүй иргэдийн хүсэлтээр Storepay үйлчилгээг бусад 21 аймаг, орон нутагт нэвтрүүлж, хэрэглэгчдийн тоог нийслэл, орон нутгийн хэмжээнд огцом нэмэгдүүлэн ажиллаж байна.



2.

Мерчант байгууллагын тоо болон хамтран ажиллах салбарын төрлийг нэмэгдүүлэх

Storepay үйлчилгээ нь өнөөдрийг хүртэл мерчант байгууллагуудтайгаа чанарын шаардлагын дагуу хамтран ажиллаж ирсэн ба одоогоор 2,700 гаруй салбар байршилд нэвтрээд байна.

2021 оны 11 сараас эхлэн бид мерчант байгууллагуудад тавигдах шаардлагыг шинэчилснээр үйл ажиллагаа нь тогтворжсон, байнгын үйлчлүүлэгч хэрэглэгчтэй, зохистой байршилд үйл ажиллагаа явуулдаг мерчантуудаас хамтран ажиллах саналыг хүлээн авч байна. Энэхүү шаардлагыг хангах 10,000 гаруй боломжит мерчант байгааг дурдах нь зөв.

Шинэчлэгдсэн нөхцөлийн дагуу Улаанбаатар хотоос үйл ажиллагааныхаа хүрээгээ тэлж, цаашлаад орон нутгийн бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах боломжтой болох юм.

2022 оны гурав дугаар сард үйлчилгээнд нэвтэрсэн Storepay 3.0 хувилбар дээр автомашин болон B2B худалдаанд ашиглах боломжтой болгосон бөгөөд үйлчилгээнүүдийн дагуу холбогдох салбарын бизнесүүдийг мерчантаар бүртгэж байгууллагын хэрэглэгчидтэй болсон.



Дотоодын зах зээлийн хөгжил

3.

Бүртгэлийн процессын шинэчлэл

Storepay аппликейшн нь өнөөдрийн байдлаар нийт 713,177 гаруй татан авалттай байгаагаас бүртгэлтэй 80%, бүртгэл дутуу хэрэглэгч 20% байна.

“СТОП ПЭЙ” ГХО ХХК нь 2021 оны 9 сард Улсын Бүртгэлийн Ерөнхий Газартай гэрээ байгуулж, Үндэсний дата төвөөс ХУР болон ДАН системийг үйлчилгээндээ нэвтрүүлэх эрхийг авсан. Ингэснээр, хэрэглэгчид хэдхэн хормын дотор өөрийн мэдээлэл, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа зэргийг манай системд илгээх боломжтой болсон.

Түүнчлэн, Storepay системийн хиймэл оюун ухаан, алгоритмын ажиллагааг улам сайжруулснаар 24/7 цагаар 365 хоногийн турш хэрэглэгчдийн хүсэлтийг хүлээн авч, хормын дотор үйлчилгээний эрх нээх боломжтой болсон.

Хэрэглэгчдийн бүртгэлийг шинэчилсний дараа бид үйлчилгээний эрх нь нээгдээгүй байгаа дээрх хэрэглэгчдийн дата баазыг шинэчилж, бүх хэрэглэгчдэд дахин шинээр бүртгэл үүсгэн үйлчилгээний эрх нээлгэх боломжийг олгон шинээр бүртгэл хүлээн авч байна.



4.

Идэвхтэй хэрэглэгчдийн үйлчилгээний эрхийг нэмэгдүүлэх

Өнөөдрийн байдлаар Storepay-д 250,000 гаруй идэвхтэй хэрэглэгч байгаа ба эдгээр хэрэглэгчид үйлчилгээний эрхийн үнийн дүнг нэмэгдүүлэх нийтлэг хүсэлтийг тавьдаг.

Бид шинэ хэрэглэгчийн үйлчилгээний эрхийг хамгийн дээд тал нь 3,000,000₮ тогтоон нээж, цаашдаа хэрэглэгч худалдан авалт төлж дуусах тутамд буцаан олголт олгох, 2 худалдан авалт тутамд 1 удаа эрхээ нэмэх боломжийг олгосон системээр ажиллаж байна.

Storepay үйлчилгээний бизнес модель нь Монголын зах зээлд анхдагч нь бөгөөд өмнө нь дотоодын санхүүгийн салбарт хэрэгжиж байгаагүй учир үйлчилгээний эрсдэлийг тооцон энэхүү шийдвэрийг гаргав.

Харин өнөөдрийн байдлаар Storepay хэрэглэгчдийн сэтгэл ханамж, санхүүгийн сахилга бат хангалттай өндөр түвшинд байгааг нийт чанаргүй эргэн төлөлтийн хувиас (0.33%) харагдана.





4.

Идэвхтэй хэрэглэгчдийн үйлчилгээний эрхийг нэмэгдүүлэх

Бид 2021 оны 11-р сараас эхлэн шинэ хэрэглэгчийн үйлчилгээний эрхийг ХУР системээр дамжуулан Нийгмийн Даатгалын Шимтгэл (НДШ) төлөлт дээр суурилан 100,000- 3,000,000 төгрөг хүртэл үүсгэж байна. SPC экосистемийн хүрээнд нийт хэрэглэгчдэдээ SPC токений тухайн үеийн зах зээлийн үнэлгээг 2 болон 4 дахин нэмэгдүүлсэн байдлаар 10 сая төгрөг хүртэл боломжит худалдан авалтын дүнгээ нэмэгдүүлэх боломж олгож байна.

Шинэ болон НДШ төлдөггүй үйлчилгээний эрх нь 0 төгрөгөөр үүссэн хэрэглэгчид 2 дахин нэмэгдэх бол нийт 3 худалдан авалт амжилттай төлж дуусгасан хэрэглэгчдийн Storepay үйлчилгээ ашиглах боломжит дүн нь SPC токений зах зээлийн үнэлгээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү дүнгээр үүсэж байна.



5.

Шинэ үйлчилгээнүүдийг Storepay 3.0 хувилбарт нэвтрүүлэх

Бид үйл ажиллагаагаа эхэлсэн цагаас хойш Storepay аппликейшнд 50 гаруй тест хийж, продакшн хувилбаруудыг гарган хөгжүүлэлт, шинэчлэлт, сайжруулалтын ажлуудыг хэрэглэгчдэдээ хүргэжээ.

Storepay аппликейшнийн сүүлийн том шинэчлэлт нь Storepay 2.0 хувилбар бөгөөд уг хувилбараар бид цоо шинэ UI/UX, хялбарчлал, сайжруулалт, Premium хэрэглэгчийн эрх, Storepoint буцаан олголт, Merchant system зэргийг танилцуулсан.

Тэгвэл энэ удаа 2022 оны гурав дугаар сард багтаан үйлчилгээнд нэвтрүүлсэн хамгийн том шинэчлэлт бүхий Storepay 3.0 болон Storepay Business хувилбаруудыг бид танилцуулж байна.

Storepay 3.0 app (2022 оны 3 сар)

Storepay Auto – Автомашины дилер компаниудтай хамтран Storepay үйлчилгээг ашиглан ямар ч хүү шимтгэлгүйгээр хуваан төлөх нөхцөлөөр 10 саяас 150 сая төгрөг хүртэлх үнэ бүхий автомашин худалдан авах боломжтой.




6.

Storepay B2B үйлчилгээ

Бид B2B үйлчилгээ нэвтрүүлсэн цагаас эхлэн үйлчилгээний эрх нээлгэх хүсэлтийг авч байгаа бөгөөд хүсэлт илгээх байгууллага шаардлагатай бичиг баримт болон 5 шалгуурыг хангаснаар ажлын 48 цагийн дотор үйлчилгээний эрх нээх эсэх талаар хариу авах боломжтой.

Storepay B2B (2022 оны 5 сар)

- Storepay B2B үйлчилгээ нэвтэрснээрээ Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд ямар ч хүү, шимтгэл, нэмэлт төлбөргүй хамгийн таатай нөхцөлөөр худалдан авалт хийх боломжтой болсон анхдагч үйлчилгээ юм.
- SPC token болон SPC экосистемийн хүрээнд B2B үйлчилгээний эрх нээлгүүлэх байгууллага Storepay-ээс заасан шаардлагатай хэмжээнд SPC байршуулах нөхцөлтэй.
- B2B үйлчилгээний эрх нь 10 саяас 100 сая төгрөг хүртэлх дүнд нээгдэх боломжтой бөгөөд үйлчилгээний эрхээ нээлгэсэн байгууллага хүссэн Storepay мерчантаас худалдан авалт хийх боломжтой бөгөөд өөрсдийн үйлчилгээний эрхийн хүрээнд хэдэн ч худалдан авалт хийх боломжтой.





7.

Шинэ төлбөрийн сонголтууд

Storepay аппликейшнийн сүүлийн том шинэчлэлт нь Storepay 3.0 хувилбар бөгөөд өмнө нь хэрэглэгчид 45 хоногт 4 хуваах болон 60 хоногт 3 хуваан төлөх сонголтуудтай байсан бол Storepay 3.0 хувилбар дээр шууд төлөх болон 4 сарын хугацаанд 5 хуваан төлөх цоо шинэ боломжууд нэвтэрсэн.



Шууд төлөх

Энэхүү нөхцөл нь хэрэглэгчдэд худалдан авалтын төлөлтөө шууд төлж хаах, худалдан авалтын 1%-ийн буцаан олголтыг өөрийн SPC Wallet-д авах зэрэг боломжийг олгож байна.



4 сарын хугацаанд 5 хуваан төлөх

Premium түвшний хэрэглэгч 2 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалтаа 4 сарын хугацаанд хуваан төлөх боломжийг олгож буй үйлчилгээ бөгөөд урьдчилгаа 50% төлснөөр худалдан авалт баталгаажна.



Урьдчилгаагүй 60 хоногт 4 хуваан төлөх (2022 оны 4-р улирал)

Storepay үйлчилгээний хэрэглэгчид заавал эхний төлөлт буюу урьдчилгаа төлж худалдан авалтаа баталгаажуулдаг байсан бол энэхүү шинэ үйлчилгээгээр SPC эзэмшигчид худалдан авалтын үнийн дүнгийн 25%-тай тэнцүү хэмжээний зах зээлийн үнэлгээ бүхий SPC токенийг Wallet-даа байршуулан худалдан авалтаа ямар ч урьдчилгаа төлөхгүйгээр 45 хоногт 4 хуваан төлөх нөхцөлөөр авах боломжтой болно.



Гадаадын зах зээлийн хөгжил

Storepay Coin | Whitepaper



Гадаадын зах зээлийн хөгжил

Storepay LLC, Mongolia

Үүсгэн байгуулагдсан
2019.01.23

Storepay Holding, Singapore


Үүсгэн байгуулагдсан
2020.06.22

Storepay, Indonesia

Бүтэц, холболт, борлуулалтын
ажлууд хийгдэж байгаа
2022.09

 Active

 Target market





Гадаадын зах зээлийн хөгжил

1.

Олон улсын корпораци болох эхлэл тавигдсан

2020 оны зургаадугаар сарын 22-нд

Бид гадаад зах зээлрүү Storepay үйлчилгээг нэвтрүүлэх төлөвлөгөөний дагуу **Storepay HOLDING PTE** толгой компанийг Сингапур улсад үүсгэн байгуулж, Multinational Corporation бүтцэд шилжих эхлэлээ тавьсан бөгөөд үүний дагуу Зүүн өмнөд Азийн зах зээлд судалгаа шинжилгээ хийн Индонез улсыг эхний боломжит зах зээлээр сонгосон.





2.

Эхний алхам: Индонезийн зах зээл

Storepay апп-г нутагшуулан нэвтрүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн холболтын ажил хийгдэж байна. Мөн борлуулалтын баг хамтран ажиллах мерчант болон бусад байгууллагуудыг нэмэх шатанд төсөл үргэлжилж байна.

Тэгвэл яагаад Индонез гэж?

- **Хүн ам:** 274 сая
- **Зах зээлийн онцлог:**
Зүүн өмнөд азийн орнууд дундаас Индонез улсын “Одоо аваад дараа төлөх” зах зээл 58% буюу 2025 он хүртэл хамгийн хурдацтайгаар хөгжих төлөвтэй байгаа.
- **Өсөн нэмэгдэж буй крипто хэрэглэгчид:**
Индонезийн худалдааны яамны мэдээлснээр тус улсад 14 сая гаруй крипто хэрэглэгчид бий бөгөөд энэ тоо нь өдөр ирэх тусам нэмэгдэж байгаа.
- **Хурдан хөрвөх боломж:**
Хэрэглэгчдийн зан төлөв, хэрэглээний хувьд Монголтой ойролцоо учир хэрэглэгчдэд хурдан хүрэх магадлал өндөр.



Гадаадын зах зээлийн хөгжил

3.

Зүүн Өмнөд Азийн зах зээлийн тэлэлт

Storepay компанийн хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигч FrontCapAsia Ltd компани нь Франц, Тайланд, Сингапур, Хонг Конг, Лаос, Танзани, Тунис зэрэг Ази, Европ, Африк тивүүдэд газар тариалан, хоол хүнс, харилцаа холбоо, үүлэн технологи, блокчейн технологи зэрэг бизнесүүдэд хөрөнгө оруулалт хийж олон төрлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг нь Storepay үйлчилгээг олон улсын зах зээлд нэвтрүүлэхэд хамгийн том түлхэц болон хамтран ажиллаж байна.



Active



Target market





3.

Зүүн Өмнөд Азийн зах зээлийн тэлэлт





Гадаадын зах зээлийн хөгжил

3.

Зүүн Өмнөд Азийн зах зээлийн тэлэлт

Блокчейн технологи, крипто хөрөнгийн давуу талууд болох хил хязгаар, газар нутаг, орон зайг үл хамааран ашиглагдах боломж нь бидэнд энэхүү нэвтрүүлэлтийн ажлыг хийх гол хүчин зүйл нь болж байгаа бөгөөд Storepay үйлчилгээ нэвтэрсэн бүхий л зах зээлд SPC token нь нэгдмэл байдлаар ашиглагдан зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлсэн олон улс хоорондын экосистем бүрдүүлэх боломжийг нээж байна.

SPC token нь Storepay үйлчилгээ нэвтэрсэн улсуудын дотоодын крипто биржүүд болон олон улсын крипто биржүүдэд арилжаалагдах бөгөөд аль ч улс орны хэрэглэгч ашиглах, хоорондоо арилжаалах боломжийг бүрдүүлэх юм.



Storepay + StorePay Coin




Бүтэц Баг хамт олон

Storepay Coin | Whitepaper



Компанийн эцсийн өмчлөгч

Эцсийн өмчлөгчийн нэр:
Жийл Гурьер Де Думаст
Хувьцааны тоо: **46**



Эцсийн өмчлөгчийн нэр:
Нэргүй Хангал
Хувьцааны тоо: **54**



Бүтэц, баг хамт олон



Нэргүй Хангал

Стор Пэй ХХК
Үүсгэн байгуулагч,
Гүйцэтгэх захирал

Стор Пэй Холдинг Сингапур
ТУЗ-ын Дарга

Стор Пэй ХХК-ийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал Н.Хангал нь бизнесийн салбарт 12+ жилийн туршлагатай 2009 онд Спортын төрөлжсөн “Sole” сэтгүүл, 2011 онд “Mobile Advertisement” компаниудыг үүсгэн байгуулж шинэлэг орчин үеийн үйлчилгээ, бүтээгдэхүүнийг Монголын зах зээлд амжилттай нэвтрүүлж байсан. Дэлхий дахинд өргөнөөр нэвтрээд буй BNPL бизнес моделийг 2019 оноос Монголд нэвтрүүлэх төслийг эхлүүлж гадаадын хөрөнгө оруулалт амжилттай татан нэгэн цоо шинэ Финтек үйлчилгээг хэрэглэгчдэд амжилттай хүргэн төслийг бүтнээр нь удирдан ажиллаж байна.

Н.Хангал нь 2012 онд МУИС-ийн Бизнесийн удирдлагын бакалавр, 2016 онд Австрали улсын Квинсландын Технологийн Их сургуулийг Олон улсын бизнесийн Магистр, 2017 онд Хууль Сахиулахын Их Сургуулийг Эрх зүйн бакалавр зэргээр тус тус төгссөн, Эдийн Засагч, Эрх зүйч мэргэжилтэй.



Бүтэц, баг хамт олон



Жаргалсайхан Болортуяа

Стор Пэй ХХК
Ерөнхий нягтлан бодогч, МНБ

Ерөнхий нягтлан бодогч Ж.Болортуяа нь 2008 онд СЭЗДС-ийг Нягтлан бодогч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөж, 2016 онд Мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхийн гэрчилгээ авсан.

Ж.Болортуяа нь санхүү, хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагуудад +14 жил ажилласан туршлагатай. 2008 онд Монголын хөрөнгийн зах зээлд хувийн Дилерүүдийн арилжааны төв байгуулах зорилгоор байгуулагдсан Мосдак ХХК-д нягтлан бодогч, төслийн мэргэжилтнээр ажлын гараагаа эхэлж, Монголын хөдөө аж ахуйн бирж, Монголын эрдэс баялгийн биржүүдийн төслийн Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах багуудад ажиллаж, биржүүд үүсгэн байгуулагдах үед ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан.

Монголын үнэт цаасны бирж ХК-д ажиллаж байх хугацаандаа биржээр дамжуулан олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх хэд хэдэн төслийн санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зөвлөгөө өгч ажилласан мэргэжлийн боловсон хүчин бөгөөд 2022 оны 05 дугаар сараас Стор Пэй ХХК-ийн багт ажиллаж байна.



Бүтэц, баг хамт олон



Жийл Гурьер Де Думаст

Стор Пэй Холдинг Сингапур
ТУЗ-ын гишүүн

ФронтКап Ази Лимитед (FrontCap Asia Limited) ба Фронтиерс Капитал (Frontiers Capital SAS) компаниудын ТУЗ-ын дарга. Жийл Гурьер де Думаст нь банкны салбарт 35 жил ажилласан туршлагатай. Тэрээр 2005 онд Калёон (Кредит Агрикол)-д орлогч ерөнхий менежер, сурталчилгааны болон хөрөнгө оруулалтын банкны олон улсын даргаар ажиллаж байсан.

Францын эдийн засаг, санхүү, аж үйлдвэрийн сайд Эрвэ Гаймарын тусгай зөвлөх болон Лондон дахь Дойче банкны Францын хөрөнгө оруулалтын банкны тэргүүний үүргийг гүйцэтгэж байсан. Европын Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн; Лондон дахь Францын КСФБ д хамтрагч тэргүүн болон Нью-Йорк дахь Олон улсын Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнээр; Парис, Нью-Йорк дахь JP Morgan мөн түүнчлэн Лондонд Bankers Trust-д Европын стратегийн дериватив бүлгийн даргаар тус тус ажиллаж байсан.

Мөн тэрээр Хөрөнгийн менежментийн Европын хамгийн том компани болох Амунди Групп (Amundi Group)-ийн Гүйцэтгэх захирлын ахлах зөвлөх, Амунди Саут Азия (Amundi South Asia) ба Амунди Норт Ази (Amundi North Asia) компаниудын зөвлөлдөх зөвлөлийн үүсгэн байгуулагч, гишүүн юм. Жийл нь Парисын Улс төр судлалын дээд сургуулийг (Sciences Po) санхүүгийн магистрын зэрэгтэй төгссөн.





Бүтэц, баг хамт олон



Алберт Момдиан

Стор Пэй Холдинг Сингапур
ТУЗ-ын гишүүн

Сокотра Капита (Sokotra Capita) ба ФронтКап Ази Лимитед (FrontCap Asia Limited) компаниудын үүсгэн байгуулагч ба Гүйцэтгэх захирал. Тэрээр UBS AG, HSBC, Credit Suisse, Merrill Lynch ба Crédit Agricole-CIB зэрэг олон улсын санхүүгийн зах зээлийн томоохон тоглогч компаниудад хөрөнгө оруулалтын банкираар 25 жил ажилласан туршлагатай.

Ойрх Дорнод, Хойд Африкийн (MENA) бүс нутгийн Ultra High Net Worth буюу 30 саяас дээш ам.долларын хөрөнгөтэй харилцагчдын банкираар ажиллаж байсан. Тэрээр тухайн бүс нутгийн төр засгийн төлөөлөгчид, компанийн Гүйцэтгэх болон санхүү хариуцсан захирлуудтай ойрын харилцаатай байдаг бөгөөд тус бүс нутгаас гадагш болон бүс нутаг руу хийгдсэн томоохон хөрөнгө оруулалтуудын төслүүдэд зөвлөхөөр ажиллаж байсан.

Тэрээр газар тариалан болон тус салбарын агритек буюу газар тариалангийн технологийн салбарт нарийн мэргэшсэн туршлагатай. Алберт нь Францын Парис-Дофины Их Сургуулийг ОУ-ын санхүүгийн магистраар төгссөн.



Бүтэц, баг хамт олон



Сэсилия Баррадаc

Стор Пэй Холдинг Сингапур
ТУЗ-ын нарийн бичгийн дарга

ФронтКап Ази Лимитед ба Фронтриерс Капитал компаниудын хөрөнгө оруулалтын шинжээч, ахлах ажилтан. Хойд болон Зүүн Өмнөд Ази бүс нутагт хөрөнгө оруулалтын шинжилгээ, төслийн менежментийг хариуцаж ажилласан 9 жилийн туршлагатай.

Тогтвортой хөрөнгө оруулалт болон тойрог эдийн засгийн (circular economy) салбаруудад идэвхтэй оролцдог. Парисын алдарт Улс төр судлалын дээд сургуулийг (Sciences Po) болон Лондоны Эдийн Засгийн Сургууль (London School of Economics) -ыг ОУ-ын эдийн засгийн хөгжил ба Эдийн засгийн түүхээр хос магистрын зэрэг хамгаалсан.

Брюссель дахь Мексик улсын элчин сайдын яам, Мексикийн Эдийн Засгийн Хөгжлийн яам болон ЮНЕСКО-гийн Дэлхийн Өвийн төвд ажиллаж байсан туршлагатай.




ICT GROUP

Системийн хөгжүүлэлтийн
чиглэлээр хамтран
ажиллагч

АйСиТи групп ХХК нь 2013 онд Монгол улсын стратегийн салбар болох Мэдээллийн технологи, Харилцаа холбооны салбарт группийн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдсан.

Группийн үндсэн чиг үүрэг нь охин компаниудаа нэгдмэл удирдлага, бодлого зохицуулалтаар ханган ажиллах бөгөөд одоогоор 32 компанид хөрөнгө оруулалт хийн, ажиллаж байна. АйСиТи групп болон түүний охин компаниуд нь 2019 оноос "Storepay" үйлчилгээний систем хөгжүүлэлтийн ажлыг хариуцан хамтран ажиллаж байгаа бөгөөд хамгийн сүүлийн үеийн технологи, аюулгүй ажиллагаа, шилдэг инженерчлэлийн шийдлүүдийг "Storepay" платформд нэвтрүүлэн ажиллаж байна.





Санхүү, хөрөнгө оруулалт
менежментийн чиглэлээр
хамтран ажиллагч

MICC нь хөрөнгө оруулалтын банкны цогц үйлчилгээг 2005 онд анх Монголд нэвтрүүлж, үүнээс хойш IPO, хаалттай хувьцаа, зээлийн санхүүжилт, компанийн нэгдэлт, худалдан авалт зэрэг нийтдээ нэг тэрбум гаруй долларын үнэлгээ бүхий 30 гаруй хэлцлийг амжилттай гүйцэтгээд байна.

MICC компани нь 2019 оноос "Storepay" төсөл дээр хөрөнгө оруулалт болон санхүүгийн менежментийн асуудлууд дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх, судалгаа болон төлөвлөгөө боловсруулах чиглэлээр хамтран ажиллаж байна.



Хууль зүйн зөвлөх
үйлчилгээ үзүүлэгч

“Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХН нь мэдээлэл технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нийлүүлдэг компаниуд тухайлбал, цахим худалдаа, финтек, нийлүүлэлтийн гинжин хэлхээ, сэтгэл зүйд суурилсан скоринг, программ хангамж хөгжүүлэгч, хиймэл оюун ухаан, тархмал технологид суурилсан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарт болон хөрөнгийн зах зээлд холбогдох асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Мөн зохицуулалтын орчныг сайжруулах, хууль тогтоомжийн нийцлийг хангах хүрээнд мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж, хууль зүйн бодлогын болон хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлага, хэрэгжилтийн судалгаа тогтмол гүйцэтгэдэг.

Хуулийн фирм 2022 оны 7 дугаар сараас эхлэн “Стор Пэй” ХХК-д урт хугацааны хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр BNPL үндсэн үйл ажиллагаа болон SPC токенд суурилсан үйл ажиллагаанд тухайлсан зөвлөх үйлчилгээ үзүүлж, хамтран ажиллаж байна.





Эрсдэл

“Стор Пэй” ХХК нь үйл ажиллагаандаа сайн засаглалыг хэрэгжүүлэх, учирч болох эрсдэлийг тодорхойлох урьдчилан сэргийлэх чиглэлээр эрсдэлийн удирдлагын бодлого боловсруулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, үүсэж болох эрсдэлийг зохистой түвшинд удирдахыг зорин ажиллаж байна.

Эрсдэлд нөлөөлөх дараах хүчин зүйлс нийтлэг байх боломжтой бөгөөд бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй байж болно.

Хууль ёсны байдал

SPC нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу аливаа төрлийн үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл, төлбөрийн хэрэгсэлд тооцогдохгүй.

Даатгагдахгүй

SPC нь Монгол Улс болон Олон Улсын даатгалын компанид хөрөнгө оруулагчдыг хамгаалах даатгалд хамрагддаггүй.

Хууль тогтоомжийн өөрчлөлт

Виртуал хөрөнгө гаргагчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулж буй зохицуулалтын баримт бичгүүдэд өөрчлөлт оруулах тохиолдолд SPC-ийн ханшийн хэлбэлзэл үүсгэх магадлалтай.

Зах зээлийн ханшийн хэлбэлзэл

SPC-ийн үнэ цэн, зах зээлийн ханш нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалан хэлбэлзэх боломжтой бөгөөд үүнд токен гаргагч нөлөөлөх боломжгүй.

Эдийн засгийн өөрчлөлт

Макро эдийн засгийн нөхцөл байдал, валютын ханшийн өөрчлөлт, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, өрсөлдөгчийн үйл ажиллагаа зэргээс хамааран компанийн үйл ажиллагаа доголдох, санхүүгийн алдагдалд орох, зах зээлд эзлэх хувь хэмжээ буурч ханшийн хэлбэлзэл, алдагдал үүсэх боломжтой.

Гадаад хүчин зүйлс

Хэрэглэгчийн санаатай болон санамсаргүй үйлдлээс хамааран хувийн мэдээллээ алдах, аливаа гэмт хэргийн шинжтэй халдлагад өртөх, бирж, гуравдагч этгээдийн буруутай үйл ажиллагаатай холбоотойгоор SPC-ийн ханшийн хэлбэлзэл, алдагдал үүсэх боломжтой.



Storepay албан ёсны хуудсууд



Виртуал хөрөнгөнд хийсэн технологийн аудитын дүгнэлттэй танилцах:

Certik Audit:

<https://www.certik.com/projects/storepay-coin>



View BscScan:

<https://bscscan.com/token/0x1eaffd6b9ef0f45d663f3fbf402226c98609600e>.



Хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, олимпийн гудамж, Нью-Хоризонс тауэр, 3 давхар, 304 тоот



Утас:

7611-0111



И-Мэйл:

info@storepay.mn



Вэбсайт:

<https://storepay.global>



Telegram:

<https://t.me/storepayspc>



Discord:

<https://discord.gg/jFXgubpG>



Facebook:

<https://www.facebook.com/storepay.mn>



Instagram:

<https://www.instagram.com/storepay.mn/>



Medium:

<https://storepayspc.medium.com/>



Twitter:

https://twitter.com/Storepay_SPCFIN



Анхаарал хандуулсанд баярлалаа

Улаанбаатар, 2022